

97,8% нь өөрийн улсын тусгаар тогтнолыг санал нэгтэй сайшааж, батлан гарын үсгээ зурцгаасан. Энэхүү санал хураалтыг ажиглах тусгай төлөөлөгчид ДИУ-аас ирж тус улсын ард түмэн байлдан олсон тусгаар тогтнолоо бататган хадгалах зориг эрмэлзлэл төгс нэгдмэл саналтай байгааг нүдээр үзсэнээ засгийн газартаа уламжлахаа албан ёсоор мэдэгдсэн билээ.

ДИУ 1945 оны 1-р сарын 5-ны өдөр БНМАУ-ын тусгаар тогтнолыг зөвшөөрөн хүлээж, улмаар 1946 оны 2-р сарын 13-нд тус хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтсон юм. Энэ нь манай ард түмэн төрийн тусгаар тогтнолоо байлдан олж, шинэ амьдралаа цогцлон байгуулахын тулд шаргуу тэмцэж, үгүйсгэшгүй амжилтанд хүрсэн, манай засгийн газраас хувьсгалт Монгол улс, ДИУ-ын хооронд хэвийн харилцаа тогтоох явдалд зуучилж өгөхийг бүр 1921 оны 9-р сард хүссэний дагуу ЗХУ-ын хийсэн нөр их чармайсны үр дүн, Хятадын дэвшилт, хувьсгалт олон түмэн монголын тусгаар тогтнолыг дэмжиж, засгийн газартаа ямар нэг хэмжээгээр нөлөөлсөн зэргээр тайлбарлагдана.

БНХАУ-ын ШИНЭТГЭЛИЙН ҮЕИЙН ГАДААД БОДЛОГО (1979—1989)

Л. Бэгзжав

Аливаа улсын гадаад бодлого дотоод бодлогынхоо үргэлжлэл төдийгүй тухайн улсынхаа стратеги бодлогын нэг хэсэг байдаг. 80-аад оны үед БНХАУ-ын гадаад бодлого тус орны дотоод улс төрийн арга хэмжээ, олон улсын байдлын нааштай өөрчлөлттэй холбоотой явж ирлээ. «Гадаад бодлогыг дотоод бодлогоос салгаж үзэхээс илүү хортой үзэл байхгүй»¹ гэж В. И. Ленин тэмдэглэсэн билээ. Үнэхээр тус орны шинэтгэлийн үеийн гадаад бодлого ХКН-аас дэвшүүлсэн «Хятадын онцлогтой социализм» байгуулах стратеги зорилттой нягт уялсан даатай, харилцан шүтэлцээтэй байгаа юм. 70-аад оны эцсээс эхлэн БНХАУ үйлдвэрлэх хүчнээ хөгжүүлэх, аж ахуйн үр ашигтай механизм бий болгох, улс орныхоо шинжлэх ухаан-техникийн чадавхийг орчин үеийн түвшинд хүргэх зорилго бүхий шинэтгэл хийж эхэлсэн билээ. Өргөн цар хүрээтэй, урт удаан хугацаа шаардсан шинэтгэлийн энэ зорилтыг хэрэгжүүлэхэд юуны өмнө, гадаад ертөнцтэй харилцаагаа өргөжүүлэх явдал тус орны өмнө тавигдсан юм.

ХКН-ын 1978 оны XII сарын III бүгд хурал 1979 оноос эхлэн нам, ард түмний анхаарлыг социалист дөрвөн шинэчлэлтийг хэрэгжүүлэхэд чиглүүлэх болов. Ингэхдээ дотооддоо эдийн засгийн шинэтгэл хийх, гадаадад нээлттэй байх бодлого дэвшүүлсэн юм. Хятадын хөгжлийн стратегийг боловсруулан гаргахдаа «асуудалд бодитой хандах», гадаад бодлогодоо ангич байр суурь, нийгмийн байгуулал, үзэл суртлын ялгааг гол болголгүй, харин эдийн засгийн хувьд

1. Тегеран. Ялта. Потсдам. Баримт бичгийн эмхэтгэл. УБ., 1973. 216 217-рт
2. «Цзюньши шилинь» сэтгүүл, Бээжин, 1988, 36—43—49-рт
3. «Үнэн» сонин, 1945, VIII. 29

ямар ашигтай, шинжлэх ухаан-техникийн ололт, тэргүүний техни технологи олж авах боломжтой эсэхийг харгалзах болов. Өөрөөр хэлбэл, БНХАУ-ын гадаад улс төрийн бодлогыг тус орны нийгэм эдийн засгийн ашиг сонирхолд зохицуулан, дэлхий ертөнцөд гарч буй бодит өөрчлөлтийг тусгах хандлагатай болов. Чухам энэ үеэс буюу ХКН-ын Төв Хорооны 1978 оны III бүгд хурлаас хойш БНХАУ-ын гадаад бодлогын шинэ үе эхэлсэн юм. Энэ үед тус орны гадаад улс төрийн бодлогод урьдынхаас ялгагдах нэлээд хувьсал гарсан нь ХКН ын XII их хурлын (1982) шийдвэрт тусгалаа олжээ. Их хурал БНХАУ ын гадаад бодлогын шинэ стратегийг албан ёсоор зарлав. Их хурлын баримт бичгээс үндэслэн энэ стратегийн үндсэн өөрчлөлтийг авч үзвэл:

— Бие даасан хараат бус бодлогыг шинээр дэвшүүлэн гаргав. Энэ нь тус их хурлын «социалист шинэтгэлийг шинэ байдалд бүх талаар нь гаргая»² тайлан илтгэлд тэмдэглэсэнээр “хэт их гүрэн» болох Зөвлөлт Америкийн аль нэгний хараанд орохгүй, аль ч талтай нь холбоотон болох буюу стратегийн холбоо тогтоохгүй байх, тухайн үеийн олон улсын ямар нэг үйл явдалд зохицож олон улсын асуудлаархи байр суурь, үзэл бодлоо өөрчлөхгүй байх явдал ажээ. Хятад улс 70-аад оных шигээ ЗХУ-ыг дэлхийн шинэ дайны гол аюул гэж үзэхээ больж, АНУ-ыг оролцуулан олон улсын нэгдмэл фронт байгуулж Зөвлөлтийн эсрэг тэмцэх стратегиа өөрчлөв;

— Энх тайвнаар зэрэгцэн орших 5 зарчмын үндсэн дээр Зөвлөлт, Америк болон дэлхийн бүх улс оронтой харилцан ашигтай хэлхээ холбоо тогтоон хөгжүүлэх чиг шугам баримтлах болов;

— Хятад улс «гуравдагч ертөнцөд» хамаарах бөгөөд хөгжиж байгаа орнуудтай харилцаагаа хөгжүүлэх нь Хятадын гадаад бодлогын нэн чухал тал гэдгийг нотлов;

— Мөн биеэ даасан хараат бус, бүрэн тэгш эрхтэй, харилцан хүндэтгэх, дотоод хэрэгт үл оролцох 4 зарчмын үндсэн дээр олон улсын Коммунист хөдөлгөөнтэй харилцаагаа сэргээн тогтооход бэлэн байгаагаа илэрхийлэв;

— Социалист байгуулалтандаа бүх хүчээ зориулах тийм нөхцөл, олон улсын аятай орчин бий болгохын тулд “Дэлхийн энх тайвныг хамгаалах» явдлыг стратегийн нэг гол зорилтоо болгосон зэрэг болно.

Хэдийгээр энэ үед олон улсын нэлээд асуудлаархи хятадын чиг шугам хэвээр үлдсэн ч гадаад бодлогодоо оруулсан эдгээр засвар өөрчлөлт нь сөргөлдөөнийг гэтлэн давах, санал зөрөлдөөнөө аль болох багасгах, олон улсын тавцанд хамтран ажиллах чигт чанарын ахиц гарсаныг харуулж, улмаар ХКН-ын XI их хурлаас хойшхи жилүүдэд улам гүнзгийрч баяжлаа. Хятадын гадаад бодлогын эдгээр хувьсал өөрчлөлт нь дотоодын нийгэм-эдийн засгийн асуудлыг шийдвэрлэхэд гадаад хүчин зүйл хэрэгтэйг, тухайлбал шинэтгэлийн эхний жилүүдийн практикаас урган гарсан бусад улс орнуудтай маргаантай асуудлаа зохицуулах, хил хязгаарын амгалан тайван байдлыг хангах, улс орныхоо нэр хүндийг сэргээх, гадаад эдийн засгийн харилцаагаа идэвхжүүлэх, тэр дундаа социалист орнуудтай харилцаагаа өргөтгөх шаардлагатайг харуулсан юм. Нөгөө талаар Хятадтай харилцах талаар социалист орнуудын, мөн нэгэн адил капиталист орнуудын бодлогод өөрчлөлт гарсан нь Хятадын бодлогод зохих ёсоор нөлөөллөө.

Хятадын шинэтгэлийн явц гүнзгийрэх тусам гадаад бодлогыг улс орны хөгжлийн зорилттой уялдсан бодит, практик хандлагатай болгох, өрнөдтэй тогтоосон харилцаанаас бий болсон зохисгүй хандлагыг гэтлэн давах оролдлого бий болов.

Дэлхийн олон улс оронтой харилцах явцдаа БНХАУ-ын олон улсын нэр хүнд, нөлөө, жин ямагт өсөхийн хирээр тус орны гадаад

бодлогын хувьсал гүнзгийрч, шинэ хандлагаар баяжив. 80-аад онд олон улсын байдалд гарсан өөрчлөлт, дотоодын шинэтгэлийн хэрэгцээ шаардлагыг тусгасан «БНХАУ-ын бие даасан, хараат бус, энх тайванч гадаад бодлогын 10 гол чиглэл, үндсэн зарчим»³-ыг БНХАУ тунхаглалаа. 1986 оны 3-р сарын 25-нд БХАТИХ-ын VI дахь удаагийн IV чуулган дээр дэвшүүлсэн энэхүү 10 зарчим нь БНХАУ-ын гадаад бодлогын шинэ хандлагыг системтэй илэрхийлжээ. Эдгээр зарчим нь 80-аад онд хятадын гадаад бодлогод гарсан нааштай хувьслыг бататган, нэлээд зохицуулалт, нэмэлт хийж, цаашид баримтлах чиг шугамаа тодорхойлж буй БНХАУ-ын гадаад бодлогын үйл ажиллагааны программын шинжтэй үндсэн баримт бичиг болж байна. Энэхүү үндсэн зарчимд томъёолсныг товчоор авч үзвэл: БНХАУ-ын гадаад бодлогын үндсэн зорилт нь жанжлалын эсрэг, энх тайвныг хамгаалахын төлөө, улс түмний найрамдал, хамтын ажиллагааг хөгжүүлэх, эдийн засгийн хамтын цэцэглэлтэд түлхэц үзүүлэх явдал юм. БНХАУ бүх улс түмэн адил тэгш эрхтэй, орон бүхний ард түмэн тус тусынхаа хэрэг явдлыг өөрсдөө мэдэх ёстой гэж үзэж байна. Хятад улс олон улсын аливаа асуудалд өөрийн бодит байдлаас хандана, аль нэг их гүрэнтэй холбоотны буюу стратегийн холбоо тогтоохгүй, энх тайвнаар зэрэгцэн орших 5 зарчмыг удирдлага болгож, бүх улс түмэнтэй хэвийн харилцаа тогтоох буюу сэргээж хөгжүүлнэ гэдгээ дахин тунхаглалаа. Мөн Хятад улс гуравдагч ертөнцөд хамаарах ба энэ ертөнцийн улсуудтай эв нэгдэл, хамтын ажиллагаагаа бэхжүүлэн зузаатгахыг гадаад үйл ажиллагааныхаа үндсэн байр суурь гэж үзэж байгааг тэмдэглээд, империализм, колоничлол, арьс өнгөөр ялгаварлан гадуурхахыг эрс эсэргүүцэхээ илэрхийлсэн байна. Хятад улс зэвсэглэлээр хөөцөлдөх, түүнийг сансарт дэлгэрүүлэхгүйн төлөө байгаага онцлон тэмдэглэжээ. Хятад улс капиталист, социалист, хөгжингүй, хөгжиж буй бүх оронтой нээлттэй харилцахаа зарлав. Эцэст нь НҮБ-ын үйл ажиллагааг дэмжиж; олон орны ард түмний хэлхээ холбоогоо хөгжүүлж, эдийн засаг, соёл, боловсрол, шинжлэх ухаан техник, хэвлэл, эрүүлийг хамгаалах, биеийн тамирын зэрэг хамтын ажиллагааг дэмжинэ тэжээ.

1987 оны X сард хуралдсан ХКН-ын XIII их хурал Хятадын гадаад улс төрийн чиг шугамыг тусгайлан авч үзээгүй юм. Дэн Сяопины хэлснээр «намын XI их хурал дээр олон улсын бодлогыг маш бага ярьсан нь Хятад улс олон улсын үйл явцыг үл хайхарч байна гэсэн үг биш бөгөөд харин 1978 оны III бүгд хурлаас боловсруулсан гадаад бодлогыг батлан тогтоож, энэ бодлогыг хойшид ч баримтлана гэсэн үг» ажээ.⁴ Их хурлын тайлан илтгэлд: «Хятад улс бие даасан, хараат бус, энх тайванч гадаад бодлогоо хойшид ч тууштай баримтлах ба энх тайвнаар зэрэгцэн орших 5 зарчмын үндсэн дээр Дэлхийн бүх оронтой найрамдал, хамтын ажиллагааны харилцаа тогтооно. Энхийг эрхэмлэгч улс орон, дэлхийн бүх ард түмний хамтаар олон улсын байдлыг даян дэлхийн энх тайван, сайн сайхны төлөө байлгахад бүх хүчээ тавих болно»⁵ гэж хамгийн товч, ерөнхий байдлаар тодорхойлсон. БНХАУ-ын албан ёсны ийм байр суурь нь олон улсын тавцанд хамтран ажиллах, дэлхийн энх тайвныг бэхжүүлэхэд чиглэж байна.

БНХАУ 80-аад оны дунд үед олон улсын амьдралд гарсан шинэ онцлог, шинэ өөрчлөлтийг харгалзан, гадаад бодлогодоо оруулсан засвар өөрчлөлтөндөө тулгуурлан, бие даасан хараат бус бодлогоо хөгжүүлэн шинэ санал, санаачилга гаргаж байна. Тухайлбал,

— Энх тайвнаар зэрэгцэн орших 5 зарчмын үндсэн дээр олон улсын улс төрийн шинэ журам тогтоох санал дэвшүүлэв. ХКН-ын Төв

Хорооны Цэргийн Зөвлөлийн дарга Дэн Сяопин 1988 оны ХП сарын 2-нд Японы олон улсын худалдаанд тус дөхөм үзүүлэх нийгэмлэгийн төлөөлөгчдийн хүлээн авахдаа энэ тухай анх дурьджээ. Дэн Сяопин: «Одоо олон улсын улс төрийн шинэ журам бий болгох цаг нэгэнт болжээ. Олон улсын улс төрийн салбарт сөргөлдөхөөс яриа хэлцээ хийхэд, хурцадмал байдлаас намжмал байдалд шилжиж, өдий төдий шинэ нөхцөл байдал гарсаны улмаас олон улсын улс төрийн шинэ журам бий болгох онолыг дэвшүүлэх хэрэгтэй»⁶ гэж тэмдэглэжээ. 35 жилийн тэртээ Азийн хоёр том гүрэн Хятад, Энэтхэг улс анхлан санаачилсан энх тайвнаар зэрэгцэн орших таван зарчмыг «өнөө үед улс хоорондын харилцаанд хэрэглэх явдлыг олон улсын улс төрийн бодлогын шинэ журам» гэж үзэж байгаагаа Төрийн зөвлөлийн ерөнхий сайд Ли Пэн мэдэгдлээ.⁷ Үүний зэрэгцээ эрх тэгш, харилцан ашигтай байх үндсэн дээр олон улсын эдийн засгийн шинэ журам бий болгох санаачилга ч гаргаж байна. Ингэхдээ аливаа улсын гадаад улс төрийн бодлого бүрэлдэн бий болоход эдийн засгийн үүрэг нэн чухал болохыг Хятадад онцлон тэмдэглэж байна.

— Зэвсэг хураах талаар БНХАУ удаа дараа нааштай санал гаргаж байсныг судлаачид өнөөдөр шинэ сэтгэлгээний үүднээс эргэн харж байна. Анх 1964 онд Хятад улс атомын бөмбөг турших үедээ «Хэзээ ч, ямар ч нөхцөл, тохиолдолд цөмийн зэвсгийг түрүүлж хэрэглэхгүй гэсэн үүрэг авснаа зарлаж байлаа. 1986 онд Хятадын засгийн газар агаар мандалд дахин цөмийн туршилт хийхгүй гэдгээ мөн зарлалаа. Түүнчлэн улсын төсөвт батлан хамгаалах зардлын эзлэх хувь 1979 онд 17,5% байсан бол 1988 онд 8% болон буурчээ. Хятадын цэргийн зардал 5,5 млрд, америк доллар. Энэ нь тус орны нэг хүнд дунджаар 5 доллар ноогдож байгааг Хятадын ГЯЯ-ны сайд Цянь Цичэнь 1988 оны VI сард НҮБ-ын зэвсэг хураах тусгай чуулганы индрээс мэдэгдсэн юм.⁸ Сүүлийн жилүүдэд тус улс зэвсэгт хүчнээ нэг сая хүнээр хорогдуулж, цэргийн олон тооны үйлдвэрийг иргэний зориулалтанд шилжүүлэв. БНХАУ цөм, сансар, хими, биологийн болон үй олноор хөнөөгч бусад төрлийн бүх зэвсгийг бүх нийтээр бүрэн хураах, ердийн зэвсэглэлийг их хэмжээгээр хорогдуулахын төлөө байна. Хятадын гадаад бодлогод эдийн засгийн хүчин зүйлийн үүрэг өсөхийн хирээр цэрэг-стратегийн хүчин зүйлийн үүрэг буурч байгааг судлаачид тэмдэглэж байна.⁹

— Сүүлийн жилүүдэд БНХАУ Ази-Номхон далайн бүс нутагт анхаарлаа хандуулах болов. 200 сая орчим хүн ам оршин суудаг далайн эрэг орчмын 291 хот, хошуудын нийт 320 мянган км газар нутгаа Хятад улс нээлттэй бүс болгож,¹⁰ тэнд гадаадын капиталыг их хэмжээгээр оруулах зорилго тавилаа. Тус улс гадаад худалдааныхаа 70 орчим хувийг Ази-Номхон далайн бүс нутгийн улс орнуудтай хийж байна.¹¹

— Хятадын засгийн газар зүүн өмнөд Азийн улсуудын Холбоо ны (АСЕАН) гишүүн орнуудтай харилцаагаа хөгжүүлэхийн тулд 1988 оны XI сард 4 зүйлт санал дэвшүүлэв. Үүнд:

1. Улс хоорондын харилцаанд энх тайвнаар зэрэгцэн орших 5 зарчмыг чанд сахина.
2. Ямар ч нөхцөлд жанжлалыг эсэргүүцэх зарчмыг эрс баримтлана.
3. Эдийн засгийн харилцаанд тэгш эрхтэй, харилцан ашигтай хамтран хөгжих зарчмыг хатуу баримтлана,
4. Олон улсын хэрэг явдалд бие даасан хараат бус, харилцан хүндэтгэх, нягт хамтран ажиллах, харилцан дэмжих зарчмыг баримтлах эдгээр болно.¹² Хятад улс АСЕАН-ы гишүүн 6 орноос Индонез,

Сингапур, Брунейтэй дипломат харилцаагүй, Малайз, Филиппинтэй түүхээс уламжилсан иргэний харьяалалын асуудлаар, мөн газар нутгийн талаар Филиппинтэй маргаантай байгаа юм. Ли Пэн ерөнхий сайд болсоныхоо дараа гадаадад анхны айлчлалаа 1988 оны XI сард АСЕАН-ы гишүүн Тайланд, мөн Австрали, Шинэ Зеландад хийсэн нь түүний өөрийнх нь тодорхойлсноор «Хятад улс Ази, Номхон далайн бүс нутгийн олон оронтой эдийн засаг, шинжлэх ухаан техникийн солилцоог идэвхтэй хөгжүүлж, энэ бүс нутгийн хамтын ажиллагаанд түлхэц өгч, тус бүс нутгийг энх тайван, найрамдал, хамтын ажиллагааны талбар болгохыг зорьж байна»¹³ гэсэн БНХАУ-ын засгийн газрын байр суурийг илтгэн харууллаа.

БНХАУ-ын шинэтгэлийн эхний үеийн үр дүнг ХКН-ын XIII их хурал (1987) гаргаж: «Практик ажлын 9 жил, ХКН-ын Төв Хорооны XI дэх удаагийн III бүгд хурлын чиг шугам үнэн зөв, марксизмын чиг шугам байсныг илтгэн харууллаа. Энэ чиг шугам нам, ард түмний оюун ухааны, ХКН-ын Төв Хорооны хамтын оюун ухааны үр шим байлаа»¹⁴ гэж дүгнэсэн юм. Шинэтгэлийн эхний 10 жилийн гадаад бодлогыг дүгнэн авч үзвэл:

— БНХАУ 70-аад онд баримталж байсан гадаад бодлогынхоо олон баримталалыг өөрчилж, бие даасан хараат бус бодлогыг хэрэгжүүлэв. Ингэснээр Хятадын гадаад бодлогод мэдэгдэхүйц хувьсал гарч, тус улсын олон улсын нэр хүнд эрс дээшлэв. Энэ хугацаанд АНУ, Португали, Ангол, Никарагуа, Палестин зэрэг 21 улстай дипломат харилцаа тогтоосноос Азийн 3, Африкийн 5, Европын 2, Америкийн 9, далайн 2 орон байв. Одоо БНХАУ Азийн 31, Африкийн 48, Европын 29, Америкийн 21, Далайн 7, нийт 136 оронтой дипломат¹⁵ мөн 180 гаруй улс, бүс нутагтай худалдаа-эдийн засгийн харилцаатай байна.¹⁶ Шинэтгэлийн 10 жилд БНХАУ-ын эдийн засагт дорвитой амжилт гарч, гадаад харилцаа идэвхжин, гадаад эдийн засаг-худалдаа өргөжихийн хирээр Хятадын дотоод, гадаад бодлого улам бүр уялдаатай болов. Өнгөрсөн хугацаанд Хятадад гадаадтай хамтарч, хөрөнгө оруулсан буюу гадаадынх дангаараа оруулсан үйлдвэр аж ахуйн газар 15 мянга орчим болж, гадаадынхтай хамтарч шинжлэх ухаан техникийн 3500 гаруй төсөл хэрэгжүүллээ.¹⁷

-- 80-аад оны Хятадын гадаад бодлогын гол онцлогийн нэг нь ЗХУ болон социалист бусад орнуудтай харилцаагаа аажмаар хэвийн болгож өргөтгөн хөгжүүлсэн явдал юм. Энэ үед Хятад социалист орнуудын харилцаа чанарын шинэ түвшинд гарч, энэ үйл явц олон улсын нийт уур амьсгалд нааштай нөлөөлж, социализмын олон улсын нэр хүндийг өргөлөө. Ялангуяа дэлхийн хоёр том гүрэн ЗХУ, БНХАУ-ын харилцаа бүрэн хэвийн болж, хөрш хоёр социалист орны харилцааны зарчмын шинэ үе эхэлсэн нь онцгой түүхэн ач холбогдолтой үйл явдал мөн. ЗХУКН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга, ЗСБНХУ-ын Дээд Зөвлөлийн дарга М. С. Горбачев 1989 оны V сард БНХАУ-д айлчилж, Хятадын нам, төрийн дээд удирдагчидтай хэлэлцээ хийснээр ЗХУКН, ХКН-ын харилцаа олон жилийн дараа дахин сэргэж, хоёр орны бүх талын харилцаа өрнөн хөгжих баттай үндэс тавигдлаа. Зөвлөлт, Хятадын харилцаа ийнхүү бүрэн хэвийн болсон нь зөвхөн хоёр орон, хоёр ард түмний хувь заяанд төдийгүй, дэлхийн энх тайвны үйл хэрэгт түүхэн чухал ач холбогдолтой юм. Хоёр талын харилцааны хөгжилд шинэ үеийн зааг болж буй Зөвлөлт Хятадын дээд хэмжээний энэ уулзалтын үр дүн нь Ази, Номхон далайн бүс нутаг орчин үеийн олон улсын харилцааг эрүүлжүүлэхэд оруулсан хамтын жинтэй хувь нэмэр мөн, 80-аад онд Зөвлөлт, Хятадын худалдааны нийт эргэлт 10 дахин өсч, 1988 оны эцсээр 2 млрд. рубль,¹⁸

1989 онд өнгөрсөн оныхоосоо 17 орчим хувь өсч 3,1 млрд, америк долларт¹⁹ хүрсэн боловч дэлхийн эдийн засгийн бодлогод нөлөө бүхий хоёр том орны хувьд чамлалттай байна. Гэвч хоёр талд хамтын ажиллагааны асар их нөөц, боломж байгаа юм.

Хөрш зэргэлдээ социалист хоёр орон БНМАУ, БНХАУ-ын харилцаа сүүлийн жилүүдэд хоёр талын хүчин чармайлтын үр дүнд бүрэн хэвийн болж, харилцааны эрх зүйн үндэс шинэ шинэ гэрээ, хэлэлцээрээр батжиж байна. Энэ 1989 оны VI сард МАХН, ХКН-ын харилцаа сэргэж, бүрэн хэвийн болсон нь социализмын байр суурь, олон улсын Коммунист хөдөлгөөний эв нэгдлийг бэхжүүлэх үйлсэд манай хоёр намын хамтын бодит хувь нэмэр боллоо. Хятадын ГЯЯ-ны сайд Цянь Цичэнь «Хятад улс Монгол улстай найрамдалтай сайн хөрш байхыг эрмэлзэж байгаа бөгөөд БНМАУ-ын тусгаар тогтнол, бүрэн эрх, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хүндэтгэх үндсэн дээр тус улстай харилцах бодолтой байна»²⁰ гэж мэдэгдсэн нь БНМАУ, БНХАУ-ын хоорондын найрамдал, харилцан туслалцах гэрээний (1960) үзэл санааны дагуу хоёр орны харилцааг бүх талаар хөгжүүлэхийн төлөө байгаа манай нам, төрийн бодлоготой нийцэж байна.

Саяхан болтол тунхаглал төдий байсан энх тайвнаар зэрэгцэн орших зарчим Хятад социалист орнуудын харилцааны бүх хүрээг хамарч, шинэ практик, тодорхой агуулгаар улам баяжиж байна. ЗХУ болон социалист бусад орнуудтай найрамдал, хамтын ажиллагаагаа өргөтгөн хөгжүүлэх бодит шаардлага БНХАУ-ын социалист бүтээн байгуулалтын эрх ашгаас урган гарч байна.

--- АНУ, Японтой харилцаагаа өргөжүүлж хөгжүүлэх нь өгүүлэн бүхий үеийн Хятадын гадаад бодлогын гол бүрэлдэхүүн хэсэг байлаа. Хэдийгээр зарим үед Хятад-Америк, Хятад-Японы харилцаанд саад бэрхшээл байсан, одоо ч байгаа боловч ерөнхийдөө харилцаа өгсөх замаар явж ирлээ. Өнгөрсөн 10 жилийн хугацаанд АНУ, Япон болон Хятадын удирдагчдын дээд хэмжээний уулзалт удаа дараа болов. АНУ-ын ерөнхийлөгч 2 удаа (Р. Рейган 1984. IV сар, Ж. Буш 1989. II сар) дэд ерөнхийлөгч 3 удаа (Мондейль 1981, XI, Ж. Буш 1982. V сар, 1985. III сар) төрийн нарийн бичгийн дарга 2 удаа тус тус Хятадад айлчилж, Хятадаас Дэн Сяопин, Жао Зыян, Ли Сяньнянь, Ян Шанкунь, У Сюецянь нарын удирдагчид харилцан айлчлав. Мөн хугацаанд Японы ерөнхий сайд Сузуки, Фукуда, Охира (2 удаа), Накасонэ, Такэсита нар Хятадад айлчилсан бол Хятадаас Хуа Гофэн, Жао Зыян, Ли Пэн, Ху Яобан, Пэн Жэн нарын удирдагчид Японд айлчилсан байна. Удаа дараагийн эдгээр айлчлалын явцад хоёр талын хамтын ажиллагааны гэрээ хэлэлцээрүүд байгуулж, бүс нутаг, олон улсын асуудлаар саналаа солилцож байв.

Хятад АНУ-тай хамтран 600 гаруй үйлдвэрийн газар байгуулж,²¹ Хятадад гадаадаас оруулж буй хөрөнгө оруулалтын 13,3%-ийг АНУ эзэлж байна.²² Хоёр орны худалдааны хэмжээ өнгөрсөн 10 жилд 8 дахин өсч, одоо 8 млрд. долларт хүрээд байгаа ба Хятад улс АНУ-ын худалдааны 16 дахь түнш нь болжээ. Хоёр талын шинжлэх ухаан техникийн хамтын ажиллагаа өргөжиж, хамтын ажиллагааны 400 төсөл хэрэгжүүлж байна.²³

Японтой хийж буй худалдаа Хятадын гадаад худалдааны 20 орчим хувийг эзлэх болж, 2 орны худалдааны хэмжээ 19 млрд. америк долларт хүрээд байгаа аж.²⁴ 1979 оноос хойш Японоос Хятадад 10 млрд. долларын зээл олгосон бөгөөд 1990—1996 онд дахин 810 млрд. иений (6 млрд. доллар Л. Б.) засгийн газрын зээл олгохоо Япон улс 1989 онд зарласан юм.

— Шинэтгэлийн 10 жилд БНХАУ өрнөдийн орнуудын харилцаа, ялангуяа эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагаа мэдэгдэхүйц өргөжлээ. Энэ хугацаанд Хятад улс Португали, Ирландтай дипломат харилцаа тогтоож, Англи, Португалитай түүхээс уламжилсан Гонконг, Макаогийн асуудлаар хэлэлцэн тохирч, Англи, Франц ХБНГУ, Итали зэрэг 16 орны төр засгийн тэргүүн нар Хятадад айлчилж, Хятадын удирдагчид ч өрнөдийн орнуудаар олонтаа айлчлан олон тооны гэрээ, хэлэлцээр байгуулсан нь Хятадын шинэтгэлд чухал хүчин зүйл болсон юм. Хятад Европын эдийн засгийн хамтын нийгэмлэгийн (ЕЭЗХН) харилцаа ч ихээхэн өргөжлөө. ЕЭЗХН-ээс сүүлийн 5 жилд 30 сая европ мөнгөний нэгж бүхий тусламжийг Хятадад өгч,²⁵ 2 талын худалдааны хэмжээ 1987 онд 11,2 млрд. долларт хүрч АНУ-ыг гүйцэж, техникийн худалдааны талаар Япон, АНУ-аас давж гарчээ.

— БНХАУ «гуравдагч ертөнцийн» буюу Ази, Африк, Латин Америкийн хөгжиж буй улсуудтай эв нэгдэл хамтын ажиллагаагаа бэхжүүлэхийг гадаад бодлогынхоо тулгын чулуу гэж үзсээр ирэв. Хятад улс хөгжиж буй бүх оронтой харилцааны өөр өөр хэлбэр маяг баримтлах, хамтаар хөгжих зарчмыг иш үндэс болгож, эдийн засаг, худалдаа, шинжлэх ухаан-техникийн харилцаагаа идэвхтэй хөгжүүлээ. БНХАУ сүүлийн 10 жилд 21 улстай дипломат харилцаа тогтоосноос 19 нь хөгжиж буй орон байлаа. Хятадын удирдагчид хөгжиж буй орнуудаар удаа дараа айлчлан, олон тооны гэрээ, хэлэлцээр байгуулав. Тухайлбал Төрийн Зөвлөлийн ерөнхий сайд Жао Зыян, БНХАУ-ын дарга Ли Сяньнянь нар (1983, 1985, 1986 онд) Ази, Африк, Латин Америкийн 20 оронд айлчилсан нь БНХАУ-ын гадаад бодлогын томоохон үйл явдал байлаа.

Ялангуяа хөгжиж буй орны хувьд БНХАУ хөрш зэргэлдээ Энэтхэг улстай харилцаагаа сайжруулах алхам хийлээ. Төрийн Зөвлөлийн ерөнхий сайд Ли Пэний урилгаар БНЭУ-ын ерөнхий сайд Р. Ганди 1988 оны 12-р сард Хятадад албан ёсны айлчлал хийсэн нь сүүлийн 34 жилд Энэтхэгийн ерөнхий сайдын Хятадад хийсэн анхны айлчлал болов. Айлчлалын үр дүнд хоёр тал жил бүр ГЯЯ-ны орлогч сайд нарын зөвлөлдөөн хийж байх, сайдын хэмжээнд эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн холимог комисс байгуулахаар тохиролцож, 2 талын хамтын ажиллагааны хэд хэдэн хэлэлцээр байгууллаа. Хоёр орны харилцааны гол саад болох хилийн асуудлыг зохицуулах зарим тодорхой арга хэмжээ, жишээлбэл хилийн асуудлын хамтарсан ажлын хэсэг байгуулахаар тохирчээ.²⁶ Дэлхийн хүн амын гуравны нэг нь аж төрдөг, хоёул эртний соёл иргэншилтэй хөрш, хөгжиж буй хоёр орны харилцаанд гарсан энэ нааштай ахиц тус хоёр орон, ард түмний төдийгүй Ази, улмаар олон улсын харилцааны чухал үйл явдлын нэг боллоо. Хятадын ГЯЯ-ны сайд Цянь Цичэнь «Хятад улс эргэн тойрны улстайгаа хөршийн харилцаагаа хөгжүүлэхийг хүсэж байна»²⁷ гэж мэдэгдсэнийг дэлхийн олон улс түмэн анхааран ажиглаж байна.

Ийнхүү БНХАУ-ын шинэтгэлийн эхний үеийн гадаад бодлогын үндсэн хувьсал, гол чиглэлийг авч үзэхэд тус орны гадаад бодлого улс орныхоо нийгэм-эдийн засгийн хөгжлийн практик хэрэгцээг нягт харгалзан үзэж, олон улсын амьдралд нааштай нөлөө үзүүлэх болов. Хятадын гадаад бодлогод гарсан хувьсал нь энх тайвныг хамгаалах, дэлхийн олон оронтой эдийн засаг, техникийн хамтын ажиллагаагаа хөгжүүлэхэд шийдвэрлэх гадаад хүчин зүйл болов. Өөрөөр хэлбэл, гадаад бодлогын гол хандлага нь улс орныхоо дотоодод шинэтгэл хийхэд зайлшгүй шаардагдах энх тайван орчинг бий болгох,

хамтын ажиллагааг хөгжүүлэхэд чиглэж байлаа. «Энх тайван, хөгжил» гэсэн ийм бодлого нийт хүн төрөлхтний хүсэл сонирхолтой нийцэж байна. Олон улсын олон чухал асуудлаархи БНХАУ-ын байр суурьт бодитой өөрчлөлт гарсан нь улс төрийн шинэ сэтгэлгээтэй ч нийцэж байна. Аль ч улс орны гадаад бодлого өөр өөрийн өнгө аястай, үндэсний өвөрмөц онцлогтой байх бөгөөд өнөө үед олон улсын амьдралын аливаа асуудлаар бүрэн нэгдмэл байр суурьтай байх нь зайлшгүй шаардлага биш гэдгийг БНХАУ-ын гадаад улс төрийн сүүлийн 10 жилийн үйл ажиллагаа харуулж байна.

1. В. И. Ленин. Оросын хувьсгалын гадаад бодлого, зохиолууд, 25-р боть УБ., 1966, 76-р тал
2. ХКН-ын XII их хурлын баримт бичгүүд. Бээжин, 1982, (хятад хэл дээр)
3. «Чжунго вайцзяо гайлань—1987» (Хятадын гадаад бодлогын товч лавлах 1987») Бээжин, 1987, 15—19-р тал
4. Дэн Сяопин 1987 оны 12-р сарын 4-нд Японы олон улсын худалдаанд туслалцаа үзүүлэх нийгэмлэгийн дарга Сакураучи Ешиог хүлээн авч уулзахдаа ингэж хэлсэн юм. «Синьхуа юэбао» сэтгүүл, 1987, № 10-р тал
5. Жао Зыян «Хятадын онцлогтой социалист байгуулалтын замаар урагшилья» Тайлан илтгэл, XI Всекитайский съезд коммунистической партии Китая.. М., 1988, с. 69.
6. Синьхуа юэбао, 1988. № 12, 112-р талд
7. «Жэньминь жибао, 1988. XII, 20
8. «Жэньминь жибао» 1988. V1, 3
9. С. Н. Гончаров, А. О. Виноградов. К вопросу об эволюции внешнеполитической концепции КНР «Проблемы Дальнего Востока» сэтгүүл., 1988. No 4, 35-р талд
10. 1980 онд Шэньжэнь, Жухай, Шаньтоу, Сямэнь-г эдийн засгийн онцгой район, 1984 онд Шанхай, Тяньзин зэрэг 14 боомт хот, 1985 онд Хөх мөрөн, Жузян голын сав газар. 1988 онд далайн эрэг орчмын 140, хот хошууд, түүний дотор Шаньдун, Ляодуны хойгийг нээлттэй бүс болгов. Мөн Хайнань арлыг бие даасан муж болгож, эдийн засгийн онцгой район гэж зарлав.
11. А. Салицкий, КНР: поиски оптимальной внешнеэкономической стратегии. «Международная экономика и международные отношения»., 1987, No 9. с. 39.
12. «Жэньминь жибао, 1988. XI. 13
13. «Жэньминь жибао», 1988. XI. 25
14. ХШ Всекитайский съезд КПК, М., 1988, с. 7
15. «Чжунгун яньцзю» («Коммунист хятадын судалгаа) Тайваны сэтгүүл. 1989, № 268, 51-р тал БНХАУ Гренадатай 1985 оны 10-р сарын 1-нд дипломат харилцаа тогтоож Гренада Тайваньтай дипломат харилцаа тогтоосны улмаас 1989 оны 8-р сарын 7-нд Гренадаас дипломат харилцаагаа таслав.
16. «Жэньминь жибао» 1989. 1, 17
17. «Жэньминь жибад» 1989. 1. 17
18. Проблемы Дальнего Востока, 1989, № 3, с. 4
19. «Жэньминь жибар» 1989. II. 6
20. «Үнэн», 1988. XII, 6
21. Новое время, № 28, 1989, с. 35
22. «Жэньминь жибао, 1988. XI. 26
23. «Чжунгун яньцзюм сэтгүүл, 1989, № 268, 57-р тал
24. Мөн сэтгүүл, 1989, № 269, 45-р тал
25. Мөн сэтгүүл, 1989, № 269, 52-р тал
26. Синьхуа юэбао, 1988, № 12, 114-118-р тал
27. «Жэньминь жибао», 1988. VII. 16